



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/77/НА-СТА-ТШЗ

Цахим <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он	хуудас:	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512123
--	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....</b>	<b>11</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН.....</b>	<b>13</b>
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>15</b>
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага.....	15
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>16</b>

#### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Орүүлалт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.04 № 729  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН  
ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
С.ӨНӨРЖАРГАЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно. Эм эмнэлгийн хэрэгсэл болох ковидийн тест, нэг удаагийн халаад, малгай, нүүрний хаалтуудыг эм эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллагаас худалдан авалт хийжээ.

### Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 88.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>89,774,818.42</u></b>	<b><u>123,903,906.03</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3,450,722.57	41,980,014.08
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	3,450,722.57	41,980,014.08
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	3,450,722.57	41,980,014.08
31211	Төрийн сангийн харилцах	297,521.21	41,980,014.08
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	3,153,201.36	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	34,718,700.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	34,718,700.00	-
3351	Байгууллагаас авах авлага	34,718,700.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	51,605,395.85	81,923,891.95
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	35,598,099.67	68,709,152.97
35110	Тусгай зориулалттай материал	14,060,623.72	14,115,623.72
35130	Эм боох материал	21,537,475.95	54,593,529.25
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,132,296.18	11,339,738.98
35410	Бичиг хэргийн материал	1,424,750.00	1,424,750.00
35420	Аж ахуйн материал	8,475,400.00	8,870,700.00
35440	Түлш, шатах тослох материал	448,549.18	640,319.98
35460	Хүнсний материал	4,783,597.00	403,969.00
35600	Мал амьтад	875,000.00	1,875,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>339,239,311.44</u></b>	<b><u>366,717,687.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	339,239,311.44	366,717,687.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	323,839,311.44	348,214,142.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	258,094,390.00	258,094,390.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,785,732.72)	(33,306,881.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,200,000.00	58,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,800,000.32)	(42,333,333.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,679,881.08	176,163,254.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(79,990,026.36)	(96,558,388.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,424,500.00	39,354,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,275,875.50)	(19,190,819.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,889,858.00	15,173,258.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,597,682.74)	(7,381,835.66)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,400,000.00	18,503,544.39
39301	Програм хангамж	1,020,000.00	4,177,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,020,000.00)	(1,630,555.61)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,400,000.00	16,007,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(50,600.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>429,014,129.86</u></b>	<b><u>490,621,593.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,144,779.03</u></b>	<b><u>4,978,557.90</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,144,779.03	4,978,557.90
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,144,779.03	4,978,557.90
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,447,488.03	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,203,792.90
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	697,291.00	774,765.00

41361	Байгууллагад төлөх өглөг	697,291.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	774,765.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>425,869,350.83</b>	<b>485,643,035.13</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	425,869,350.83	485,643,035.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	429,702,619.72	429,702,619.72
51101	Өмч: - төрийн	429,702,619.72	429,702,619.72
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(32,644,869.97)	27,128,814.33
51210	Өмнөх үеийн үр дүн	(32,644,869.97)	(32,644,869.97)
51220	Тайлант үеийн үр дүн	-	59,773,684.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,811,601.08	28,811,601.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>429,014,129.86</b>	<b>490,621,593.03</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>746,333,769.79</b>	<b>625,441,937.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,374,726.23</b>	<b>33,793,637.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	42,374,726.23	33,793,637.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,374,726.23	33,793,637.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,374,726.23	33,793,637.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>703,959,043.56</b>	<b>591,648,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	396,301,467.56	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	14,797,367.56	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	381,504,100.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	233,227,546.00	4,626,630.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,867,546.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,360,000.00	4,626,630.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	18,407,300.00	23,520,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,407,300.00	23,520,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	56,022,730.00	563,501,570.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	56,022,730.00	563,501,570.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>679,757,611.76</b>	<b>589,883,226.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>679,757,611.76</b>	<b>589,883,226.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	651,645,111.76	587,749,356.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	328,024,689.46	322,167,178.94
210101	Үндсэн цалин	231,001,319.60	225,498,533.66
210102	Нэмэгдэл	71,800,650.90	63,345,429.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,299,872.00	4,957,999.90
210104	Урамшуулал	18,922,846.96	28,365,215.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,608,861.00	43,621,985.92
210201	Тэтгэврийн даатгал	33,114,061.00	28,005,785.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,873,700.00	4,024,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,299,000.00	3,169,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	574,700.00	1,165,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,747,400.00	7,257,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,139,981.82	19,211,261.79

210301	Гэрэл, цахилгаан	3,583,055.00	2,977,974.69
210302	Түлш, халаалт	10,556,926.82	15,508,287.10
210303	Цэвэр, бохир ус	-	725,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,157,080.00</b>	<b>34,655,680.00</b>
210401	Бичиг хэрэг	4,644,000.00	3,800,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,495,200.00	14,171,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,271,860.00	1,644,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнутгал	850,000.00	10,112,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,255,000.00	4,031,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	895,000.00
210408	Бараа материал акталсны зардал	9,641,020.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>169,979,370.35</b>	<b>81,722,667.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,342,702.35	61,545,809.80
210502	Хоол, хүнс	21,056,668.00	12,891,358.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,580,000.00	7,285,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,345,000.00</b>	<b>20,566,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,150,000.00
210604	Урсгал засвар	10,325,000.00	19,416,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>383,400.00</b>	<b>1,518,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	383,400.00	1,518,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,250,047.00</b>	<b>11,311,785.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,250,047.00	11,311,785.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,756,682.13</b>	<b>52,973,797.44</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,263,100.00	22,042,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,493,582.13	30,931,347.44
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,112,500.00</b>	<b>2,133,869.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,112,500.00</b>	<b>1,885,300.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,112,500.00	1,885,300.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>248,569.31</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	248,569.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>66,576,158.03</b>	<b>35,558,711.30</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>66,576,158.03</b>	<b>35,558,711.30</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>654,442,976.00</b>	<b>627,141,765.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>774,765.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	774,765.00
120009	Бусад орлого	-	774,765.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>654,442,976.00</b>	<b>626,367,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	381,504,100.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	381,504,100.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	233,227,546.00	4,626,630.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,867,546.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,360,000.00	4,626,630.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	23,520,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	23,520,100.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	18,407,300.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,407,300.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	21,304,030.00	598,220,270.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,304,030.00	598,220,270.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>620,476,653.43</b>	<b>535,842,873.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>620,476,653.43</b>	<b>535,842,873.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>592,364,153.43</b>	<b>533,709,004.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	325,771,201.43	324,614,666.97
210101	Үндсэн цалин	228,747,831.57	225,498,533.66
210102	Нэмэгдэл	71,800,650.90	65,792,917.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,299,872.00	4,957,999.90
210104	Урамшуулал	18,922,846.96	28,365,215.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,608,861.00	43,621,985.92
210201	Тэтгэврийн даатгал	33,114,061.00	28,005,785.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,873,700.00	4,024,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,299,000.00	3,169,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	574,700.00	1,165,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,747,400.00	7,257,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,407,300.00	15,896,530.69
210301	Гэрэл, цахилгаан	3,583,055.00	2,977,974.69
210302	Түлш, халаалт	9,824,245.00	12,193,556.00
210303	Цэвэр, бохир ус	-	725,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,199,060.00	34,108,980.00
210401	Бичиг хэрэг	4,477,000.00	3,660,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,495,200.00	14,171,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,271,860.00	1,784,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	9,493,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,255,000.00	5,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	151,403,484.00	72,632,455.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,281,959.00	56,835,225.60
210502	Хоол, хүнс	24,305,525.00	8,511,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,816,000.00	7,285,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,848,700.00	23,748,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,863,700.00	-
210602	Тавилга	660,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,490,000.00
210604	Урсгал засвар	10,325,000.00	19,258,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	383,400.00	1,518,800.00
210702	Дотоод албан томилолт	383,400.00	1,518,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,144,047.00	12,076,535.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,144,047.00	12,076,535.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,598,100.00	5,490,850.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,598,100.00	5,490,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,112,500.00</b>	<b>2,133,869.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,112,500.00	1,885,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,112,500.00	1,885,300.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	248,569.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	248,569.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>33,966,322.57</b>	<b>91,298,891.51</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>52,769,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>52,769,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	52,769,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	52,769,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>(52,769,600.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	33,966,322.57	38,529,291.51
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		3,450,722.57
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	3,450,722.57	41,980,014.08

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	(76,531,206.85)		357,118,414.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	(76,531,206.85)	-	357,118,414.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	66,576,158.03		66,576,158.03
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	(9,955,048.82)	-	423,694,572.06
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	(9,955,048.82)	-	423,694,572.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	(9,955,048.82)	-	423,694,572.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	59,773,684.30		59,773,684.30
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	49,818,635.48	-	483,468,256.36

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	830282600.00	525220106.14
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	830282600.00	525220106.14
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	828284900.00	523334806.14
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	533396300.00	314240468.93
210101	Үндсэн цалин	353951600.00	215124335.62
210102	Нэмэгдэл	142000000.00	65792917.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8444500.00	4957999.90
210104	Урамшуулал	29000200.00	28365215.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49987000.00	43621985.92
210201	Тэтгэврийн даатгал	33749500.00	28005785.92
210202	Тэтгэмжийн даатгал	4179300.00	4024000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3293700.00	3169400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	886300.00	1165800.00

210205	Эрүүл мэндийн даатгал	7878200.00	7257000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18300000.00	15896530.69
210301	Гэрэл, цахилгаан	4200000.00	2977974.69
210302	Түлш, халаалт	12500000.00	12193556.00
210303	Цэвэр, бохир ус	1600000.00	725000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40348300.00	34108980.00
210401	Бичиг хэрэг	3660400.00	3660200.00
210402	Тээвэр, шатахуун	20312900.00	14171280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,875,000.00	1,784,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,500,000.00	9,493,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	84,168,600.00	72,632,455.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,243,600.00	56,835,225.60
210502	Хоол, хүнс	14,275,000.00	8,511,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,650,000.00	7,285,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	75,096,600.00	23,748,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	37,029,900.00	-
210602	Тавилга	8,166,700.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,500,000.00	4,490,000.00
210604	Урсгал засвар	21,400,000.00	19,258,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,520,500.00	1,518,800.00
210702	Дотоод албан томилолт	1,520,500.00	1,518,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,967,600.00	12,076,535.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,967,600.00	12,076,535.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,500,000.00	5,490,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	5,490,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,997,700.00	1,885,300.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,997,700.00	1,885,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,997,700.00	1,885,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	733,171,800.00	614,519,373.32
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	23,520,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	23,520,100.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	733,171,800.00	590,999,273.32
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	733,171,800.00	590,999,273.32
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>		-
122001	Хандив тусламж /дотоод/		-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>297,521.21</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>41,980,014.08</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төв нь “Хүн амд эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлж ажиллана.” гэсэн зорилгын хүрээнд мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж, ард иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлдэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,607.4 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар буурсан байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>			
Мөнгөн хөрөнгө	3,450.7	41,980.0	38,529.3
Авлага	34,718.7	-	34,718.7
Бараа материал	51,605.4	81,923.9	30,318.5
Үндсэн хөрөнгө	339,239.3	366,717.6	24,478.3
Нийт хөрөнгө	429,014.1	490,621.6	61,607.4
Өр төлбөр	3,144.7	4,978.5	1,833.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	425,869.3	485,643.0	59,773.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	429014.1	490,621.6	61,607.4

- Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 41,980.0 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 81,923.9 мянган төгрөг болж 30,318.5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 33,056.0 мянга, тусгай зориулалтын материал 55.0 мянга, аж ахуйн материал, түлш тослох материал 587.0 мянга, мал амьтад 1000.0 мянга, нийт 34,698.0 мянган төгрөгөөр үлдэгдэл өссөн, хүнсний материал 4,379.6 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 366,717.6 мянга болж 61,607.4 мянгаар өссөн нь Төсвийн хөрөнгөөр нэн шаардлагатай машин тоног төхөөрөмж 53,698.3 мянга, тавилга эд хогшил 7,909.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.
- Авлагын дансны эцсийн үлдэгдэл 34,718.7 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн сайдын А/337-99 тоот тушаалын дагуу ковид-19 цар тахлаар хэвтэн эмчлүүлсэн иргэний төлбөр эрүүл мэндийн даатгалаас сангаас олгогдсон байна.
- Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл нүүрсний үнэ төлөгдөөгүй байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 485,643.0 мянган төгрөг болж 59,773.6 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төслөөр ЭМДС-аас авах санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан 733,171.8 мянган төгрөгөөр төлөвлөж, баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 733,198.1 мянга, орон нутгийн санхүүжилт 23,300.0 мянга нийт 756,498.1 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 588,612.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 598,220.2 мянга, орон нутгийн санхүүжилт 23,520.0 мянга, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан 5,401.4 мянга, нийт 627,141.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 248.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 41,980.0 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 588,612.4 мянган төгрөг буюу 66.1 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	23,300.0	15,989.2	7,310.0	68.6
2	80302-Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон	353,114.7	171,211.4	181,903.3	47.6
3	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	380,083.4	376,054.1	4,029.2	98.9
4	83201-Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээ	7,714.0	5,097.7	2,616.3	84.8
5	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	66,070.9	20,260.0	45,810.9	30.6
<b>НИЙТ</b>		830,282.6	588,612.4	241,670	66.1

*Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс 185,932.6 мянган төгрөг хасагдсан байна. Энэ нь боловсон хүчин дутмаг, зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцээгүйтэй холбоотой байна.*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 679,757.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,196.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад түлш халаалтын зардал 4,951.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тээвэр шатахууны зардал 2,323.4 мянга, гэрэл цахилгаан зардал 605.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.
- Түлш халаалтын зардал: нүүрсний үнэ, шатах тослох материалын үнэ өмнөх оноос өссөн нь нөлөөлөл үзүүлжээ.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>3</sup> заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгсөн.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

<sup>1</sup> Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

<sup>3</sup> бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төв нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	-	2		100
Нийт дүн	2		2		100

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,701.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,601.0 мянган төгрөгийн зөрчилд<sup>4</sup> төлбөрийн акт тогтоож, 15,100.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, зөрчил дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цэвэрлэгээний материалыг 7,959.0 мянган төгрөгөөр худалдан авч, норм нормативаас хэтрүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь төсвийн тухай хуулийн 16.5.5<sup>5</sup>, 41.2.2<sup>6</sup>, 41.2.3<sup>7</sup> дахь заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Албан хаагч нарт 1,412.0 мянган төгрөгөөр биеийн тамирын хувцас худалдан авч өгсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1<sup>8</sup> дахь заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийлгүй, төсвийн хөрөнгөөр 4,900.000 төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>9</sup> дахь заалтыг зөрчсөнд албан шаардлага өгөв.

5.2.2 Эм эмнэлгийн хэрэгсэл болох ковидын тест, нэг удаагийн халаад, малгай, нүүрний хаалтуудыг 10,200.000 төгрөгөөр эм эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах, ханган

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>5</sup> батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/

<sup>6</sup> батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарах

<sup>7</sup> төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

<sup>8</sup> Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно

<sup>9</sup> Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно

нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллагаас худалдан авалт хийж нөөц бэлтгэсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6<sup>10</sup>, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>11</sup>, Зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.19<sup>12</sup> заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

5.2.3 Эм эмнэлгийн хэрэгсэл болох ковидын тест, нэг удаагийн халаад, малгай, нүүрний хаалтууд зэргийг эм эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллагаас худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6<sup>13</sup>, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>14</sup>, Зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.19<sup>15</sup> заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

5.2.4 Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>16</sup> заасныг зөрчсөнд албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл													
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо				
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Албан хаагч нарт биеийн тамирын хувцсыг худалдан авсан	1	1,642.0	1	1,642.0									
Цэвэрлэгээний материалыг 7,959.000 төгрөгөөр худалдан авч норм нормативаас хэтрүүлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ	1	7,959.0	1	7,959.0									
Цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийлгүй, төсвийн хөрөнгөөр 4900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн байна.	1	4,900.0			1	4,900.0							
Эм эмнэлгийн хэрэгсэл болох ковидын тест, нэг удаагийн халаад, малгай, нүүрний хаалтуудыг 10,200.000 төгрөгөөр эм эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй	1	10,200.0			1	10,200.0							

<sup>10</sup> нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх

<sup>11</sup> Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно

<sup>12</sup> Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно

<sup>13</sup> нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх

<sup>14</sup> Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно

<sup>15</sup> Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно

<sup>16</sup> бонд, зээл, өрийн бичиг, баталеа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшилийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

